

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1 Оршил.....	4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3 Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.12 Шилэн дансны мэдээлэл .....	9
2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	9
2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Малын удмын сангийн үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан .....	10
3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	14
3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
3.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	19
4. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	20

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2020.02.19 № 06/527  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Малын удмын сангийн үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Малын удмын сангийн үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Малын удмын сангийн үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Аудитын гол асуудал


Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор хөрөнгө дутагдсан, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө тасарсан зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Малын удмын сангийн үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус төвийн захирал П.Ганхуяг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн орлогын данстай холбоотой зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Малын удмын сангийн үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Малын удмын сангийн үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Лидер экаунт аудит” ХХК-ийн аудитор Э.Учралзаяа хариуцаж хэрэгжүүлэв.

Малын удмын сангийн үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 16 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## 2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

### Эрхэм зорилго:

Малын удмын сангийн үндэсний төв нь мал сүргийг генийн түвшинд төрийн хамгаалалтад авч, малын үржлийн ажил, үйлчилгээнд биотехнологи, генийн инженерчлэлийн дэвшилтэт аргыг нэвтрүүлснээр малын ашиг шим, бүтээмжийг нэмэгдүүлэн мах, сүүний дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, улмаар мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

### Үйл ажиллагааны чиглэл:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны А/187 дугаар тушаалаар “Малын удмын сангийн үндэсний төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийг баталсан байна. Малын удмын сангийн үндэсний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Мал сүргийн удмын санг хамгаалах, ашиг шимийн гарц, чанарыг сайжруулах ажлыг зохион байгуулах, мал үржүүлэг, нөхөн үржихүйн чиглэлээр гаргасан эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх;
- Арвин ашиг шимт хээлтүүлэгч малын үр, хөврөл үрийг үйлдвэрлэх, үйлдвэр, үйлчилгээнд нэвтрүүлэх, нөөцлөх, генийн сан бий болгох;
- Цөм сүргийн үржлийн төв, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг үр, хөврөл үрээр хангах;
- Өндөр ашиг шимт хээлтүүлэгч малын үрээр зохиомол хээлтүүлэг хийх ажил, үйлчилгээ явуулах, тухайн үүлдрийн шилмэл ангийн жишигт нийцсэн хээлтэгч, хээлтүүлэгч бойжуулах;
- Улсын хэмжээнд үржүүлж байгаа арвин ашиг шимт цөм сүргийн малын удам гарваль, ашиг шимийн мэдээллийн сан бий болгож, дүн шинжилгээ хийх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/385 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг шинээр мөрдөж ажиллаж байна.

## 2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Малын удмын сангийн үндэсний төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “ACOLOUS” программ хангамж ашигладаг байна.

Малын удмын сангийн үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

## 2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Малын удмын сангийн үндэсний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 3 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,707,842.6 мянган төгрөгөөс тооцон 17,078.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 20,731.5 мянган төгрөгөөр тооцсон нь төсөвт байгууллагад санхүүгийн тайланг баталгаажуулах аудитын үед голчлон төсөвт хөрөнгийн зарцуулалтыг авч үздэгтэй холбоотой болно.

## 2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Малын удмын сангийн үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,155,318.5 мянган төгрөгөөр буюу 26.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		93.85	93.85
Авлага	196,479.6	2,848,131.7	2,651,652.1
Урьдчилгаа			
Бараа материал	1,136,742.7	4,554,949.8	3,418,207.1
Үндсэн хөрөнгө	18,514,568.2	17,600,027.4	-914,540.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>19,847,790.5</b>	<b>25,003,109.0</b>	<b>5,155,318.5</b>
Өр төлбөр	15,319.2	13,101.6	-2,217.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	19,832,471.3	24,990,007.3	5,157,536.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>19,847,790.5</b>	<b>25,003,109.0</b>	<b>5,155,318.5</b>

Авлага дансны үлдэгдэл 2,651,652.1 мянган төгрөгөөр өссөн нь жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор 189,471.5 мянган төгрөгийн дутагдал гарсан ба ХХААХҮСайдын 2019 оны А/247 дугаар тушаалаар Мал хамгаалах сангаас балансаас балансад шилжүүлсэн 2,450,000.0 мянган төгрөгийн авлагууд нэмэгдсэнээс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2014-2016 онуудад үүссэн, он удаан жил болсон 104,045.0 мянган төгрөгийн байгууллага, хувь хүнээс авах авлага байна. Үүнээс мал дутагдуулсан, эзэн холбогдогч нь нас барсан, Төрийн өмчийн хороо /хуучин нэрээр/-ноос шилжиж ирсэн цаашид барагдах боломжгүй найдваргүй авлага байгаа бөгөөд үүнийг шүүхийн байгууллагад өгсөн ч шийдвэрлэгдээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3,418,207.1 мянган төгрөгөөр өссөн нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/179 дугаар тушаалаар Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилт” төслийн зээлийн хөрөнгийн санхүүжилтээр худалдан авсан 600,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий өндөр ашиг шимт малын үрийг шилжүүлэн авсан, мөн сайдын 2019 оны А/242 дугаар тушаалаар Мал хамгаалах сангийн эргэлтийн хөрөнгөнд бүртгэлтэй 512,138.9 мянган төгрөгийн бэлэн бүтээгдэхүүн, 2,000.0 мянган төгрөгийн аж ахуйн материал, 2,304,068.2 мянган төгрөгийн мал, амьтдыг балансаас балансад шилжүүлж авснаас голлон шалтгаалжээ. 2019 онд 150,326.3 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалт хийж, байгууллагын үйл ажиллагаанд зарцуулжээ

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 914,540.6 мянган төгрөгөөр буурсан нь 188,778.6 мянган төгрөгийн дутагдсан хөрөнгийг залруулах бичилт, 725,762.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэл байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/179 дугаар тушаалаар үнэ төлбөргүй хүлээн авсан 20,235.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгджээ.

Биет бус хөрөнгө 1,259.0 мянган төгрөгөөр өссөн нь программ хангамж худалдан авсантай холбоотой байна.

Байгууллага, хувь хүмүүст өгөх өглөгийг барагдуулснаар өр төлбөр дансны үлдэгдэл 2,217.6 мянган төгрөгөөр буурчээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 24,990,007.3 мянган төгрөг болж 5,157,536.0 мянган төгрөгөөр өссөн нь хуримтлагдсан үр дүн нэмэгдсэнээс шалтгаалжээ. Энэ нь үйл ажиллагааны нийт үр дүн 2,707,536.0 мянган болсонтой холбоотой байна.

Дутагдсан 189,471.5 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн данснаас хасч, авлагаар тусган залруулах бичилт хийсэн.

## **2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Малын удмын сангийн үндэсний төв тайлант онд 355,431.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 221,964.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 62.0 хувиар биелүүлсэн байна.

Орлого 133,467.5 мянган төгрөгөөр тасарсан нь дотоодод үйлдвэрлэсэн 1 тун үрийн үнэ өндөр байгаагаас шалтгаалан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд захиалгаар үйлчлүүлэх идэвх буурсан, импортын үрийн үнэ, худалдан авалтын үнээс шалтгаалаад харьцангуй өндрөөр нийлүүлэгддэг тул тухайн үнээр зохиомол хээлтүүлэг хийлгэх иргэд, аж ахуйн нэгжийн тоо буурсан байна.

Туслах үйл ажиллагааны орлого нь цөм сүргийн мал болон түүхий эд, зааз малын мах борлуулсны орлогоос бүрддэг бөгөөд өнгөрсөн жил хээлтүүлэгч малын борлуулалтын захиалга ирээгүйгээс шалтгаалан орлого тасарсан байна.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 942,574.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 942,574.8 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 587,143.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 355,431.7 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.



Зардлыг нэр төрлөөр авч үзэхэд хэтэрсэн зардал байхгүй бөгөөд урсгал зардлыг 153,891.9 мянган төгрөгөөр хэмнэлттэй зарцуулжээ. Үүний дотор цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 29,793.9 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 2,641.2 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 54,433.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэжээ. Цалин хэмнэгдсэн нь малын эмч, үр үйлдвэрлэлийн мэргэжилтний орон тоог хоёр хүнээр нэмэгдүүлж, төсвийг батлуулсан ч тус 2 хүнийг авч ажиллуулаагүйтэй холбоотой.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 788,682.8 мянган төгрөг буюу 83.7 хувь байна.

Төсвийн нэмэлт санхүүжилтээр 16,678.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, үүнээс 2,038.0 мянган төгрөгийг зарцуулж, 14,640.5 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

## **2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 6 эрсдэл тодорхойлж, нийт 9 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 355,938.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 4,133.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 189,471.5 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 162,333.1 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар дараах зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1.Тайлант онд тооллогоор 189,471.5 мянган төгрөгийн хөрөнгө дутагдсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 зүйлийн 18.1 дэх заалттай нийцэхгүй, эрх үүрэг, иж бүрэн байх, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Шийдвэрлэсэн нь:

Тооллогоор дутагдсан хөрөнгийг байгууллага, хувь хүнээр төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 28,865.7 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 зүйлийн 20.2.6 дэх заалттай нийцэхгүй, оршин байх, эрх үүрэг, иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Шийдвэрлэсэн нь:

28,865.7 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах албан шаардлага хүргүүлэв.

3.Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 133,467.4 мянган төгрөгөөр тасарсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.4 дэх заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Шийдвэрлэсэн нь:

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг тасалсан шалтгааныг тодорхойлж, хэрэгжүүлэх талаар албан шаардлага хүргүүлэв.

## **2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Импортоор худалдан авсан болон үйлдвэрлэсэн үрийн үнэ өндөр байгаагаас аж ахуй нэгж, иргэд худалдан авах нь цөөрсөн нь өөрийн орлогын төлөвлөгөө тасрах үндэслэл болж

байна. Иймд өөрийн орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөх үүднээс үрийн худалдах үнийг зөв тогтоох шаардлагатай байна.

Тооллогоор дутагдсан хөрөнгийг төлүүлж, тайланд тусгасан болон үндсэн хөрөнгө, үрийн тооллогыг хийж тооцоо бодсон эсэхийг дараагийн аудитаар авч үзэх.

## **2.12 Шилэн дансны мэдээлэл**

Малын удмын сангийн үндэсний төвийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 44 мэдээллийг хугацаанд нь, 97 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

## **2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 131,685.7 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлснээс 25,800.0 мянган төгрөгийн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Нийт 3 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатандаа байна.

## **2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Малын удмын сангийн үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүнг бидний тогтоосон материаллаг байдлын дүнгээс хэтэрсэн тул хязгаарлалттай дүгнэлт өгч байна.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Малын удмын сангийн үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 3. Малын удмын сангийн үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан

#### 3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,333,222,323.83</b>	<b>7,403,081,578.36</b>
<b>2</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>		<b>93.85</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>		<b>93.85</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>		<b>93.85</b>
<b>31213</b>	Арилжааны банкин дахь харилцах		93.85
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	196,479,645.28	<b>2,848,131,705.41</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	37,331,495.10
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>196,479,645.28</b>	<b>2,810,800,210.31</b>
3351	Байгууллагаас авах авлага	48,330,764.35	2,478,865,692.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	148,148,880.93	331,934,518.31
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>1,136,742,678.55</b>	<b>4,554,949,779.10</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	110,400,083.42	105,350,633.42
35110	Тусгай зориулалттай материал	110,400,083.42	105,350,633.42
35300	Бэлэн бүтээгдэхүүн	229,606,111.53	1,314,539,252.99
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	105,573,624.12	94,826,026.48
35410	Бичиг хэргийн материал	-	90,000.00
35420	Аж ахуйн материал	58,687,606.09	57,589,625.07
35430	Сэлбэг хэрэгсэл	775,000.00	979,000.00
35440	Түлш, шатах тослох материал	3,881,473.53	2,604,146.91
35460	Хүнсний материал	24,303,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	17,926,544.50	33,563,254.50
35600	Мал амьтад	691,162,859.48	3,040,233,866.21
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>18,514,568,203.39</b>	<b>17,600,027,452.01</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	18,514,568,203.39	17,600,027,452.01
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	17,624,999,715.89	16,709,199,589.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	14,531,830,823.49	14,531,830,823.49
39202	Хуримтлагдсан элэгдэл	(378,165,594.49)	(787,299,884.67)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	226,618,788.60	238,484,853.60
39204	Хуримтлагдсан элэгдэл	(190,434,034.52)	(193,904,694.58)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,721,533,852.08	3,555,180,199.06
39206	Хуримтлагдсан элэгдэл	(921,793,929.76)	(1,190,410,871.12)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	578,896,351.49	578,896,351.49
39208	Хуримтлагдсан элэгдэл	(78,063,953.45)	(149,771,774.53)
39214	Бусад үндсэн хөрөнгө	178,242,924.00	178,242,924.00

39215	Хуримтлагдсан элэгдэл	(73,907,155.95)	(82,289,981.63)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	30,241,644.40	30,241,644.40
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>889,568,487.50</b>	<b>890,827,862.50</b>
39301	Програм хангамж	3,026,000.00	4,526,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,376,312.50)	(2,616,937.50)
39303	Бусад биет бус хөрөнгө	888,918,800.00	888,918,800.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>19,847,790,527.22</u></b>	<b><u>25,003,109,030.37</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>15,319,221.60</u></b>	<b><u>13,101,675.89</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	15,319,221.60	13,101,675.89
<b>412</b>	<b>Богино хугацаат зээлийн өглөг</b>	-	-
<b>4121</b>	<b>Төгрөг</b>	-	-
41214	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл		-
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>15,319,221.60</b>	<b>13,101,675.89</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	11,392,984.88	11,392,984.88
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	107,142.40	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	3,819,094.32	1,708,691.01
41361	Байгууллагад төлөх өглөг	2,958,685.32	1,708,691.01
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	860,409.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>19,832,471,306.02</u></b>	<b><u>24,990,007,354.48</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	19,832,471,306.02	24,990,007,354.48
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,604,070,935.15	1,604,070,935.15
51101	Өмч: - төрийн	1,604,070,935.15	1,604,070,935.15
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>17,619,466,006.47</b>	<b>22,777,002,054.93</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	15,936,170,747.93	20,069,466,006.47
51220	Тайлант үеийн үр дүн	1,683,295,258.54	2,707,536,048.46
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	608,934,364.40	608,934,364.40
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>19,847,790,527.62</u></b>	<b><u>25,003,109,030.37</u></b>

### 3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,991,278,211.00</b>	<b>4,410,197,239.92</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,423,696,011.00</b>	<b>3,806,375,639.92</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,423,696,011.00	3,806,375,639.92
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,423,696,011.00	3,806,375,639.92
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,178,000.00	206,834,412.79
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,404,518,011.00	3,599,541,227.13
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>567,582,200.00</b>	<b>603,821,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	525,662,200.00	587,143,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	525,662,200.00	587,143,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	41,920,000.00	16,678,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	41,920,000.00	16,678,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,704,560,806.41</b>	<b>2,073,146,704.71</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,704,560,806.41</b>	<b>2,073,146,704.71</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,625,291,168.16	2,035,310,090.78
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>278,713,825.09</b>	<b>269,359,466.22</b>
210101	Үндсэн цалин	225,557,669.78	221,811,211.44
210102	Нэмэгдэл	32,106,155.31	27,443,254.78
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,050,000.00	20,105,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>33,378,085.98</b>	<b>38,223,032.28</b>
210201	Тэтгэврийн даатгал	22,828,764.80	26,543,086.75
210202	Тэтгэмжийн даатгал	2,806,967.50	2,871,908.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,945,187.86	2,667,118.16
210204	Ажилгүйдлийн даатгал	527,015.06	552,758.53
210205	Эрүүл мэндийн даатгал	5,270,150.76	5,588,160.82
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		-
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>87,832,391.91</b>	<b>100,831,177.02</b>
210301	Гэрэл, цахилгаан	10,958,328.00	26,743,489.00
210302	Түлш, халаалт	70,666,743.91	65,794,981.02
210303	Цэвэр, бохир ус	3,807,320.00	5,892,707.00
210304	Байрны түрээс	2,400,000.00	2,400,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>29,692,721.36</b>	<b>23,820,376.48</b>
210401	Бичиг хэрэг	3,914,750.00	2,879,100.00
210402	Тээвэр, шатахуун	18,406,585.00	15,337,177.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,781,756.36	4,057,839.48
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,589,630.00	1,546,260.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>4,504,050.00</b>	<b>3,998,500.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	678,550.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,825,500.00	3,998,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,024,480.00</b>	<b>10,225,270.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,096,900.00	1,205,980.00
210604	Урсгал засвар	5,927,580.00	9,019,290.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>14,152,282.00</b>	<b>4,765,156.15</b>

210701	Гадаад албан томилолт	9,975,652.00	-
210702	Дотоод албан томилолт	4,176,630.00	4,765,156.15
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>129,069,599.69</b>	<b>398,438,268.62</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	128,446,799.69	397,755,544.62
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		-
210803	Даатгалын үйлчилгээ	-	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	536,400.00	613,564.00
210807	Газрын төлбөр	86,400.00	69,160.00
